



АРДЧИЛСАН НАМД

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

2017.05.10 № 922

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Дүгнэлт хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.18-д заасан бүрэн эрхийн хүрээнд Сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуульд танай намаас нэр дэвшигч Халтмаагийн Баттулгын сонгуулийн мөрийн хөтөлбөрт аудит хийж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдэгдэл**

Ардчилсан нам Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Төсвийн тогтвортой байдлын тухай, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд нийцсэн байдал, мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийн талаарх тооцоо, судалгааг үнэн зөв гаргаж, нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг тооцоо судалгаанд үндэслэн, найруулгын хувьд ойлгомжтой, хоёрдмол утгагүйгээр боловсруулан Үндэсний аудитын газарт ирүүлэх үүрэгтэй.

Ардчилсан намаас Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээнүүд нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэх болон мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрт дүгнэлт өгөх нь Үндэсний аудитын газрын үүрэг юм.

**Дүгнэлтийн үндэслэл**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээг хянан үзэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-ыг, мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийн тооцооллыг шалгахдаа Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг тус тус шалгуур болгон авч үзсэн болно.

**Дүгнэлт**

**Нэг. Мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын Хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэх талаар**

Энэхүү дүгнэлтэд хавсаргасан Ардчилсан намаас Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн байна.

070349

000032

**Хоёр. Мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийн талаар**  
Энэхүү дүгнэлтэд хавсаргасан Ардчилсан намаас Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт санхүүжилт, эх үүсвэр шаардагдах зорилт, арга хэмжээнүүд тусгагдаагүй тул дүгнэлт гаргаагүй болно.

Хувийг: Сонгуулийн Ерөнхий Хороонд

Хавсралт <sup>1</sup> & хуудастай

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

## ХҮЧИРХЭГ МОНГОЛ УЛС

Мянганаар өртөөлсөн Их Монгол үндэстний төрт ёс, түүх соёл, язгуур уламжлал, орчин цагийн ололт амжилт, өрнөх ирээдүйн их хүслийн гурван цагийн хэлхээн дээр өнөд орших эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт халдашгүй дархан байдал, ардчилал, эрх чөлөө, шударга ёсыг эрхэмлэн дээдэлж хөгжин бадарсан "ХҮЧИРХЭГ МОНГОЛ УЛС"-ыг цогцлоох Үндэсний Ерөнхийлөгч байна.

- **Эв нэгдэлийг эрхэмлэж, үндэсний эрх ашгаа дээдэлсэн Ерөнхийлөгч байна.**
- **Эрх чөлөө, шударга ёсыг сахин хамгаалж, иргэдээ дэмжсэн Ерөнхийлөгч байна.**
- **Эдийн засгаа сэргээж, аж үйлдвэрийг хөгжүүлсэн Ерөнхийлөгч байна.**
- **Экологийн тэнцвэрийг хангаж, эх нутгаа хамгаалсан Ерөнхийлөгч байна.**
- **Экспортын шинэ эринг эхлүүлсэн, эрх тэгш гадаад харилцааг эрхэмлэгч Ерөнхийлөгч байна.**



## НЭГ.ЭВ НЭГДЛИЙГ ЭРХЭМЛЭЖ, ҮНДЭСНИЙ ЭРХ АШГАА ДЭЭДЭЛСЭН ЕРӨНХИЙЛӨГЧ БАЙНА.

### 1.1.Эх орон, ард түмнийхээ язгуур эрх ашгийг эрхэмлэн хамгаална.

*Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхэт байдал, газар нутаг, хил хязгаарын бүрэн бүтэн, халдашгүй дархан байдал, ардчилал, эрх чөлөө, хүний эрх, шударга ёсыг дээдлэн үндэсний язгуур эрх ашгийг тууштай хамгаалан ажиллана. Үүнд:*

- 1.1.1. Монголын ард түмэн хүсэл зоригоороо тэмцэн бүтээсэн ардчилал, шударга ёс, хувь хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн дээдэлж, батлан хамгаалах хүчин чадлыг бэхжүүлж, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхэт байдал, газар нутаг, хил хязгаарын халдашгүй дархан байдлыг бататган хамгаалах бодлогыг улам боловсронгуй болгож, хэрэгжүүлэхийн төлөө ажиллах;
- 1.1.2. Цэрэг арми, батлан хамгаалах салбарыг хөгжүүлэх, зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний хөгжил, мэргэжлийн ур чадварыг эрс дээшлүүлэх, гадаад улс орнуудтай цэргийн хамтын ажиллагаа, гадаад харилцааг хөгжүүлэх бодлого, санаачлагыг дэмжих;
- 1.1.3. Монгол Улсын хууль тогтоомж нь Үндэсний Аюулгүй байдлын Үзэл баримтлалд нийцсэн байх эрх зүйн орчинг бүрдүүлэх;
- 1.1.4. Даяаршил, технологийн хурдацтай хөгжлийн эрин үед үндэснийхээ түүхэн уламжлал, хэл, соёлын дархлааг хамгаалж, Монгол бахархал шингэсэн нүүдлийн соёл иргэншлийг хүн төрөлхтний үнэт зүйл болгох бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэхийн төлөө ажиллах;
- 1.1.5. Хөрш орнууд болон Гуравдагч хөрш орнуудтай аюулгүй байдал, хамтын ажиллагааг шинэ төвшинд гаргаж улс орныхоо бие даасан байдлыг бэхжүүлэх бодлого боловсруулж, онцгой анхаарч ажиллах.

### 1.2.Үндэсийн эв нэгдлийг эрхэмлэн бүтээнэ.

*Үндэсний эв нэгдлийг илэрхийлэгч Монгол Улсын Ерөнхийлөгчийн хувьд төрт ёсны оршин тогтнолыг чандлан хамгаалж, талцал, хуваагдлын эсрэг эвлэрэн нягтарсан, хүчирхэгжин мандсан, эв нэгдэлтэй Монголын төлөө манлайлан ажиллана. Үүнд:*

- 1.2.1. Талцал, хуваагдлыг таслан зогсоож, эвлэрэл нэгдэлд хөтөлсөн үндэсний бодлого боловсруулж, хэрэгжүүлэхийн төлөө ажиллах;
- 1.2.2. Нийгмийн бүхий л хүрээнд байгаа үгүйсгэх, гутаах, тэмцэлдэх үзлийн эсрэг байж нэгэндээ урам зориг өгөн дэмждэг, хамтран зүтгэдэг үндэсний бахархалт үзэл санаа, тэмүүллийг бий болгох бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэхийн төлөө ажиллах;
- 1.2.3. Ахмадын туршлага, идэрчүүдийн зүтгэл, залуусын тэмүүллийг уялдуулан холбож, мэдлэг туршлагаа солилцон, бие биенээ дэмждэг тогтолцоо бий болгох бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэхийн төлөө ажиллах;
- 1.2.4. Уламжлалт нүүдлийн соёл иргэншилээ хотын соёл иргэншилтэй уялдуулан хөгжүүлж аль алиныг нь хүндэтгэн бахархадаг зөв үзлийг төлөвшүүлэх бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэхийн төлөө ажиллах;



- 1.2.5. Парламентат ёс болон төрийн удирдлага, нутгийн өөрөө удирдах ёсны зарчмыг боловсронгуй болгож, төрийн тогтвортой байдал, бодлогын залгамж чанарыг хадгалах, хүний нөөцийг чадавхжуулж, үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд төрийн бодлогыг чиглүүлэхийн төлөө ажиллах;


**ХОЁР.ЭРХ ЧӨЛӨӨ, ШУДАРГА ЁСЫГ САХИН ХАМГААЛЖ,  
ИРГЭДЭЭ ДЭМЖСЭН ЕРӨНХИЙЛӨГЧ БАЙНА.**

**2.1.Шударга ёсыг тууштай сахиулж, хүний эрхийг дээдэлнэ.**

*Монгол Улсад хүний язгуур эрхийг дээдэлж, хэнийг ч үл ялгаварлан иргэнээ хамгаалсан хуулийн засаглал бүхий, хариуцлагатай, нээлттэй, ил тод, тунгалаг төрийн үйлчилгээг төлөвшүүлэх зарчмыг баримтална. Хүний эрх, эрх чөлөө, баялаг бүтээгч иргэдийнхээ эрх ашгийг хамгаалж, төрийн тогтвортой бодлогоор урамшуулан дэмжихийг эрмэлзэж ажиллана. Үүнд:*

- 2.1.1. Иргэн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, хууль ёсны эрхээ нэр төртэйгээр хамгаалуулж чадах шударга шүүхийн тогтолцоог дэмжин, эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлэхийн төлөө ажиллах;
- 2.1.2. Ил тод, шударга сонгон шалгаруулалтаар төрийн албыг мэргэшсэн, чадварлаг хүний нөөцөөр бүрдүүлж ажиллахыг бүхий л талаар дэмжинэ. Улс төрийн сонгуулийн үр дүнгээр төрийн албан хаагчдыг хоморголон халах үйлдлийг шийдвэртэй таслан зогсоох эрх зүйн орчныг бүрдүүлэн бэхжүүлэх улс төрийн манлайлал гаргаж ажиллах;
- 2.1.3. Сонгогдсон болон томилогдсон төрийн албан тушаалтан авлига, хээл хахуулийн хэрэгт холбогдсон нь тогтоогдсон, офшор данстай нь илэрсэн, ашиг сонирхлын зөрчилтэй нь нотлогдсон тохиолдолд хатуу хариуцлага хүлээлгэж, албан тушаалаас нь огцруулах, хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох, энэ асуудлыг зохицуулсан олон улсын гэрээ, конвенцэд нэгдэхийн төлөө бодлого, санаачлага гарган ажиллах;
- 2.1.4. Төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, шуурхай, шат дамжлагагүй хүргэх зорилгоор олон улсын чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, онлайн хэлбэрт шилжүүлэх, шууд ардчилал, иргэний оролцооны сайн туршлагуудыг үргэлжлүүлэн төлөвшүүлэхийг дэмжин ажиллах;
- 2.1.5. Ерөнхийлөгч ард түмэнтэйгээ хамтран төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, төсвийн зарцуулалт, төрийн өмчийн эзэмшилд хяналт тавих, үнэлэлт өгөх жишгийг тогтоосон бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэхийн төлөө ажиллах;
- 2.1.6. Иргэний үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, хэвлэн нийтлэх эрх, хэвлэл мэдээллийн бие даасан, хараат бус байдлыг хамгаалж, "Дөрөв дэх засаглал"-ын үүднээс дэмжин, хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөл, санхүүжилтын ил тод байдлыг хангах эрх зүйн орчинг бүрдүүлэх;
- 2.1.7. Шүүхийн хараат бус, бие даасан байдлыг хангахын зэрэгцээ шүүгчийн сонгон шалгаруулалтад мэргэжлийн ур чадвар, туршлагаас гадна хувь хүний ёс зүйн шаардлагыг хуульчилж, эрх зүйн орчинг боловсронгуй болгох;

**2.2.Боловсрол, соёл, урлаг, шинжлэх ухааныг дэмжих бодлого баримтална.**



Монгол Улсын хөгжлийн тулгуур, эдийн засгийн өсөлтийн эх сурвалж нь эрдэм боловсролтой, эрүүл чийрэг, ажилтай "Монгол хүн" байна гэдэг зарчимд үндэслэн монгол хүний мэдлэг, ур чадварыг дэлхийн түвшинд хүргэхийг төрийн бодлогоор дэмжих чиглэлийг тууштай баримтлан ажиллана. Үүнд:

- 2.2.1. Монгол хүний оюуны үнэ цэнэ шингэсэн туурвил, бүтээлийг бодитойгоор үнэлэх, түүний үнэлэмжийг нэмэгдүүлсэн бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих;
- 2.2.2. Монгол түмний уламжлалт ёс заншил, язгуур өв, нүүдлийн соёл иргэншил, үндэсний болон сонгодог урлагийг төрийн ивээлд байлгах, тэдгээрийг сурталчилсан монгол контентийг дэмжин хөгжүүлэх, олон улсын зах зээлд гаргах хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
- 2.2.3. Хүүхэд, залуусыг ёс зүйтэй, эх оронч үндэсний үзэлтэй, бүтээлч иргэн болж төлөвшүүлэх асуудлыг төрийн бодлогын төвд тавих, шинэ зууны хурдтай хөгжилд хөл нийлүүлэн алхах боломжийг нэмэх, интернетийн дэд бүтцийг олон улсын жишигт хүргэж, эх орныхоо аль ч өнцөгөөс дэлхийтэй холбогдон суралцах буюу ажиллах боломжийг нь нээн өгөхийн төлөө идэвхи санаачлага гарган үүнд чигэлсэн бодлого, үйл ажиллагааг дэмжих;
- 2.2.4. Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарын хүний нөөцийг бүрдүүлэх, мэдлэгт суурилсан үйлдвэрлэл хөгжүүлэх бүх санаачилгийг дэмжих;
- 2.2.5. Цэцэрлэгийн болон сургуулийн насны хүүхэд бүрт төрөөс боловсролын үйлчилгээг тэгш, хүртээмжтэй үзүүлэх, сурч боловсрох орчин нөхцлийг сайжруулахад чигэлсэн бодлого, санаачлагыг дэмжих;**
- 2.2.6. Мэргэжлийн боловсрол эзэмшигч залуучуудыг дэмжсэн төрийн бодлогыг улам боловсронгуй болгох, санал санаачлага гаргах;

### 2.3. Иргэдийнхээ эрүүл мэндийг хамгаална.

Монгол хүний эрүүл мэнд, бие бялдрын хөгжлийг монгол төрийн бодлогын үндсэн цөмд байлгах зарчим баримтална. Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах үндсэн хуулиар олгогдсон эрхийг баталгаажуулж, монгол хүний эрүүл мэндийг сахин хамгаалах, эрүүл чийрэг бие бялдартай болгон хөгжүүлэх бодлогод онцгой анхаарч ажиллана. Үүнд:

- 2.3.1. Анагаах ухааны сүүлийн үеийн дэвшилтэт технологид суурилсан эрүүл мэндийн салбарын шинэчлэлийг дэмжиж, монгол хүн эх орондоо дэлхийн төвшний оношилгоо эмчилгээ хийлгэх боломж, бололцоог бүрдүүлэхийг дэмжих;
- 2.3.2. Иргэн бүрд эрүүл мэндийн үйлчилгээг хүртээмжтэй болгох зорилгоор олон улсын жишигт нийцсэн үзлэг, шинжилгээ, оношилгооны иж бүрэн төвүүдийг бүсчлэн хөгжүүлэхэд чигэлсэн бодлого, санаачлагыг дэмжих;**
- 2.3.3. Урьдчилан сэргийлэх чиглэлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, иргэд даатгалаараа чийрэгжүүлэх болон усан спортын төвд хичээллэх боломжтой байхад чигэлсэн төрийн бодлого, эрх зүйн орчин бий болгохын төлөө ажиллах;
- 2.3.4. Аливаа төрлийн өвчлөлийг бууруулах, өвчлөлийн тэргүүн эгнээнд буй хавдар, зүрх судасны өвчлөлийг эрт оношлох, халдварт болон халдварт бус өвчний эрсдлийг бууруулах, эрүүл амьдрах хэв маягийг түгээн дэлгэрүүлэх аливаа үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих;
- 2.3.5. Нийтийн биеийн тамир, спортын дэд бүтцийг сайжруулан, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, үндэсний спортын өв соёл болон спортын анагаах ухааныг



хөгжүүлэх, тамирчдын бэлтгэл сургуулилт хийх таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх, спортыг эдийн засгийн эргэлтэд оруулах, эх орныхоо нэрийг өндөрт өргөн амжилт гаргасан баг, тамирчдаа тогтвортой бодлогоор урамшуулан дэмжих төрийн бодлого, хууль эрх зүйн орчинг улам боловсронгуй болгохын төлөө ажиллах;

#### **2.4.Мэргэшсэн төрийн албатай, иргэдийн төлөө нийтийн үйлчилгээг дэмжинэ.**

*Монгол төрийн албан хаагчдыг Монгол Улсын төрт ёсны уламжлалыг хадгалж, иргэн төвтэй нийгмийн тасралтгүй ажиллагааг ханган, бодлого боловсруулах, шийдвэр гаргах, хуулийн засаглалыг хэлбэрэлтгүй хэрэгжүүлэх үйлсээ бүтээлчээр гүйцэтгэж байх эрх зүйн болон соёл, ёс зүйн орчинг бүрдүүлэхэд анхаарна.*

*Батлан хамгаалах болон шүүх, прокурор, цагдаа хүчний байгууллагад шударга ёсыг сахиулан ажиллагч иргэдийг монгол төрийн тусгаар тогтнолын тулгуур гэж үзэх бөгөөд нийт төрийн албан хаагчдийн эрхийг хамгаалан ажиллахыг Ерөнхийлөгчийн үйл ажиллагааны нэг чиглэл болгоно. Үүнд:*

2.4.1. Төрийн албаны мэргэшсэн, чадварлаг, цомхон, үр өгөөжтэй зохион байгуулалтыг дэмжиж, туршлага, авьяас чадвар, бүтээлч хандлагад суурилсан сонгон шалгаруулалтын шинэлэг зарчмыг шингээсэн хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх, энэ чиглэлийн үйл ажиллагааг дэмжих;

**2.4.2. Төрийн албан хаагчдын ажил үүргээ хэвийн, үр дүнтэй, шударгаар, шуурхай явуулах орчин нөхцөл, цалин хангамж, орон сууцны асуудлыг шийдвэрлэхэд чигэлсэн бодлого, санаачлагыг дэмжих;**

#### **2.5.Иргэдэд чигэлсэн нийгмийн хамгааллын бодлогыг дэмжин хамгаална.**

*Иргэдийнхээ нийгмийн хамгааллын баталгааг хангаж, эзнээ олсон халамжийн бодлого хэрэгжүүлэх зарчмыг баримтлан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хувьд халамж шаардлагатай иргэдийнхээ эрхийг хамгаалагч нийгэм дэх тэгш оролцоог дэмжигч байна. Үүнд:*

2.5.1. Хүн амын зорилтот бүлгүүдэд нийгмийн халамжийн үйлчилгээг үр өгөөжтэйгээр хүргэх бодлогыг хэрэгжүүлэх, Монгол хүний дундаж наслалт, физиологи, хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөр эрхлэлтийн байдлаас хамааруулан өндөр насны тэтгэвэр авах бололцоог баталгаатай хангах тал дээр анхаарах;

2.5.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ялгаварлан гадуурхахгүй байх, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээнд тэгш хамруулах, тэдэнд зориулсан нийгмийн дэд бүтцийг бий болгох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тогтмол орлоготой болгох аливаа бодлого, үйл ажиллагааг дэмжих;


#### **2.6.Өрх, гэр бүл, ахмад, эмэгтэйчүүд, хүүхэд залуусын хөгжлийг дэмжинэ.**

*Үндэстэн оршин тогтнох эх сурвалж болсон айл өрхийн амьдралыг дэмжин, нийгэм, эдийн засгийн нэгдсэн зохицуулалтыг бий болгож, үндэсний хэмжээнд санаачилга дэвшүүлэн ажиллах нь Ерөнхийлөгчийн бодлогын цөм байна. Үүнд:*



- 2.6.1. Гэр бүл төлөвлөлт, тогтвортой байдал, гэр бүлийн харилцааны нийгэмд үзүүлэх эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх талаар соён гэгээрүүлэх, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх;
- 2.6.2. Эхчүүдийн амаржих, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, тэдний ажлын байрыг нь баталгаатай хадгалах, эдийн засгийн болон санхүүгийн дарамтанд өртүүлэхгүй байх, олон хүүхэдтэй гэр бүлийг тэтгэх, орон сууцжуулах талаар бүтээлч санаачилгуудыг дэмжих;
- 2.6.3. Өрх толгойлсон, бага орлоготой, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүүхдийг дэмжих, боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор харьяалал харгалзахгүйгээр цэцэрлэг, сургуульд хамруулах “Хүүхэд бүр цэцэрлэгт”, “Цалинтай ээж” зэрэг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хөтөлбөр, төслүүдийг дэмжиж ажиллах;**
- 2.6.4. 3 хүртэл насны хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/ болон орлого багатай өрхийг төрөөс дэмжих эрх зүйн орчинг боловсронгуй болгох Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг дэмжиж ажиллах;
- 2.6.5. Шийдвэр гаргах түвшинд жөндөрийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн оролцоо, манлайллыг бодитойгоор нэмэгдүүлэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх бодлого, үйл ажиллагааг дэмжих;
- 2.6.6. Монгол Улсад хүүхэд нэг бүрийн эрхийг хангах үндэсний тогтолцоог бэхжүүлэх замаар хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулж хүүхэд бүрт хүрэх төрийн үйлчилгээг хүртээмжтэй байлгахын төлөө бодлого боловсруулж ажиллах.
- 2.6.7. Ахмад настны цагийн хөдөлмөр эрхлэх боломжийг сайн дурын үндсэн дээр сонголтоор бий болгох, залууст ажлын дадлага, туршлага, мэргэжлийн ур чадвараа өвлүүлэх чиглэлийн бодлого, санаачлагыг дэмжих;**
- 2.6.8. Ахмад настны оношилгоо, эмчилгээ, сувилалын дагнасан сэргээн засах болон сувилахуйн үйлчилгээг хөгжүүлэх, хувийн хэвшлийн асрамжийн газар байгуулах бодлого, санаачилгыг дэмжих;
- 2.6.9. “Монголын Ирээдүй” үндэсний санаачилгын хүрээнд залуучуудыг нийгэм, соёлын манлайлалд уриалж, тэдний бүтээлч санал санаачилгуудыг идэвхитэй дэмжих;
- 2.6.10. Оюутан, залуусд цагийн ажлын байр бий болгосон, сургууль төгссөн залуучуудыг ажлын байраар хангасан аж ахуйн нэгжүүдийг дэмжих;
- 2.6.11. Залуусын эх оронч, үндэсний үзэл бүхий хүмүүжлийг дэмжин эх орноо батлан хамгаалах мэдлэг боловсрол, бие бялдар, сэтгэл зүйн хувьд төлөвшүүлэх “Оюутан Цэрэг” хөтөлбөрийг үргэлжлүүлэн дэмжиж ажиллах;
- 2.6.12. Улсын зардлаар хилийн чанадад нарийн мэргэжлээр суралцах оюутан, залуусын сонгон шалгаруулалтыг ил тод, нээлттэй, шударга болгож, өндөр хөгжилтэй орнуудын их, дээд сургуулиудад бакалавр, магистр, докторын сургалтад элсэгчдийн тоог 2 дахин нэмэгдүүлэх асуудлыг Засгийн газарт чиглэл болгон хамтран ажиллах;
- 2.6.13. Хүүхэд, өсвөр үе, залуучуудын архи, тамхи, мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, цахим донтолтын хамаарлыг бууруулах, таслан зогсооход шийдвэртэй тэмцэн хууль санаачлах;

## 2.7. Малчид, тариаланчдаа дэмжинэ.





Монгол үндэстний үе улиран уламжилж ирсэн нүүдлийн мал аж ахуйн сонгодог соёлыг тээгч малчин түмэн, эх орныхоо газрын шимээр хүн амынхаа хүнсний хэрэгцээг хангагч тариаланчдынхаа нийгмийн асуудалд онцгой анхаарч, тэднийхээ эдийн засгийн өсөлтөд чиглэсэн санал санаачилгыг төрийн бодлогод тусган ажиллана. Үүнд:

- 2.7.1. Малчид, тариаланчдын орлого болсон хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний зах зээлийн үнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого, аж амьдралын нөхцлийг сайжруулахад чиглэсэн санал санаачилгуудыг дэмжин ажиллах;
- 2.7.2. Мал аж ахуйн үйлдвэрлэлээс нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, экспортлоход чиглэсэн эдийн засгийн дэд бүтцийг бий болгоход анхаарч ажиллах;
- 2.7.3. Бэлчээрийн даацад тохируулан малын тоог чанарт шилжүүлэх, ашиг шим, хүртээмжийг сайжруулах, генетикийн нөөцийг хамгаалах, үржил селекцийн ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй явуулах, эрүүлжүүлэх, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, шинэ үүлдэр, омгийг бий болгох, мал эмнэлэг, үржлийн нэгжүүдийг чадавхижуулах, бэлчээрийг усжуулах, малчдын эдийн засгийг дэмжсэн малжуулах санаачилгыг дэмжин ажиллах;
- 2.7.4. Хилийн бүсэд амьдарч буй иргэдийг сайн дурын үндсэн дээр хил хамгаалах үйлсэд оролцуулах, цэргийн насны иргэдийг цэргийн дүйцүүлэх албанд хамруулах чиглэлийн бодлого, санаачлагыг дэмжих;**

**2.8. Төвлөрлийг сааруулах, хот байгуулах, орон нутгийн хөгжүүлэх бодлогыг дэмжинэ.**

Улсын хөгжлийг орон нутгаас эхлүүлж, нутгийн өөрөө удирдах ёс, иргэдийн оролцоог дэмжих нь Ерөнхийлөгчийн үйл ажиллагааны үндсэн чиглэл байна. Агаарын бохирдлыг бууруулах бодлого нь эн тэргүүний зорилт байна. Иргэдийн эрүүл, аюулгүй ажиллаж, амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх, боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээг газар зүйн байршлаас үл хамааран адил тэгш нөхцлөөр хүргэх боломжийг хангах хот байгуулалт, орон нутгийн хөгжлийн бодлогыг дэмжиж ажиллана. Үүнд:

- 2.8.1. Орон нутаг, аймаг сумдын төвүүдийг тухайн бүс нутгийнхаа онцлог давуу талуудад тулгуурлан аялал жуулчлал, үйлдвэрлэл, үйлчилгээг тэтгэн эдийн засгийн хувьд бие даан хөгжих боломжийг төрийн бодлогоор тууштай дэмжих;
- 2.8.2. Орон нутгаас төвлөрүүлсэн татварын тодорхой хувийг орон нутагт зориулах, зарцуулалтыг ил тод болгох, орон нутгийг бүсчлэн хөгжүүлэх бодлого, санаачлагыг дэмжих;**
- 2.8.3. Төрийн захиргааны байгууллагуудыг оновчтой байршуулах, төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулсан хүртээмжит бодлогыг дэмжиж ажиллах;
- 2.8.4. Нийслэлийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, усан сан байгуулж, Туул, Сэлбэ, Дунд голуудын урсгалыг дэмжин, орчныг сэргээн тохижуулж амралт зугаалгын бүс, хиймэл нуур шинээр бий болгох замаар хотын иргэдийнхээ амьдрах таатай орчныг бүрдүүлэх бодлого, санаачлагыг дэмжих;**
- 2.8.5. Иргэдийн аюулгүй, амгалан тайван амьдрах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөхцлийг бүрдүүлэх идэвхитэй дэмжих бодлого баримтлах;




- 2.8.6. Хүн ам олноор төвлөрсөн гэр хорооллын бүсүүдийг нэн тэргүүнд төвлөрсөн инженерийн шугам, ус хангамжийн сүлжээгээр хангах, барилгажуулах, агаар, ус, хөрсний бохирдлын асуудлуудыг цогцоор нь шийдвэрлэхэд чигэлсэн бодлого, санаачлагыг дэмжих;
- 2.8.7. Инженерийн байгууламж бүхий цэвэр бохир усны сүлжээнд холбогдсон орчин үеийн соёл, үйлчилгээний төвүүдийг төлөвлөсөн сумын төвийг хөгжүүлэх бодлого, санаачлагыг дэмжих;

**ГУРАВ.ЭДИЙН ЗАСГАА СЭРГЭЭЖ, АЖ ҮЙЛДВЭРИЙГ  
ХӨГЖҮҮЛСЭН ЕРӨНХИЙЛӨГЧ БАЙНА.**

*Эдийн засгийнхаа бүтцийг шинэчлэн олон тулгууртай болгох бодлого хэрэгжүүлж, инновацид суурилсан аж үйлдвэрийг хөгжүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг хүртээмжтэй болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд тэргүүн зэргийн ач холбогдол өгч ажиллана. 2016 оны 2 сарын 5-ний өдөр УИХ-ын №19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” хөтөлбөрийг дэмжин ажиллана. Үүнд:*

- 3.1. Монгол Улсынхаа эдийн засгийн бүтцийг шинэчлэн олон тулгууртай болгох замаар өрсөлдөх чадварыг сайжруулах, иргэдийн орлогыг нэмэгдүүлж, амьжиргааны чанарыг сайжруулахын тулд Монгол улсын төрөөс нэн тэргүүнд анхаарах ёстой чухал чиглэл бол аж үйлдвэржилт хэмээн үзэж энэ чиглэлд онцгой анхаарал тавина.
- 3.2. Аж үйлдвэрийн хөгжилд ээлтэй банк санхүү, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх бодлогыг дэмжинэ;
- 3.3. Монгол Улсын аж үйлдвэрийн бүтцийг зохиомжилж, хөгжлийн бодлогыг тодорхойлохдоо дундаж давхаргын иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, амьдралын чанарыг дээшлүүлэх талаар онцгойлон анхаарч, хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалт, эрх зүйн орчныг боловсронгуй болгохын төлөө ажиллах;
- 3.4. Эрдэс баялгийн салбарыг хөгжүүлэхдээ үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд нийцүүлэн улс төр, бизнесийн бүлэглэлийн ашиг сонирхлын зөрчилдөөний талбар болгохоос сэргийлж, баялгийн нөөц нь хууль бусаар өмчлөх аливаа төрлийн үйлдэл эс үйлдэхүйтэй тууштай тэмцэж, эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- 3.5. Байгалийн баялаг ашигласнаас олох орлогыг тусгай санд хуримтлуулан уул уурхайн бус салбарын аж үйлдвэрийн хөгжил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлд зарцуулах бодлогыг санаачилж эрх зүйн орчинг бүрдүүлэх;
- 3.6. Монгол Улсын иргэн бүр байгалийн баялагийг тэгш, шударгаар эзэмших, хувь хүртэх, үр өгөөжийг нь ашиглах боломжийг хуулиар хамгаалах бодлого, үйл ажиллагаа, санал, санаачлагыг дэмжих;
- 3.7. Монгол Улсад ган хайлуулах, зэс хайлуулах болон нефть химийн үйлдвэр бүхий аж үйлдвэрийн парк байгуулах, түүнийг дагасан боловсруулах болон хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх аж үйлдвэржилтийн хөрөнгө оруулалт, мега төслүүдийг дэмжих;
- 3.8. Монгол Улсын эдийн засаг дахь “Хүрэн эдийн засаг”-ийн хувийн жинг тогтвортой бууруулж, байгальд ээлтэй, экологийн тэнцвэрт байдлыг хадгалсан, нөхөн сэргээлт хийх бүрэн боломжтой, ил тод, хариуцлагатай уул уурхайг дэмжинэ.



22

000041

- Үндэсний аюулгүй байдал, орон нутгийн иргэдийн аливаа ашиг сонирхлыг зөрчсөн хайгуулын болон ашиглалтын лиценз олгох, олборлолт хийх хууль бус үйл ажиллагааг шийдвэртэйгээр эсэргүүцэж, таслан зогсоохын төлөө ажиллана;
- 3.9. Иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрийн чадавхитай ажиллах хүчний нөөцийг баялаг бүтээх үйлсэд татан оролцуулах, зах зээлийн эдийн засгийн харилцаанд нийцсэн хөдөлмөрийн хэлбэр, хөдөлмөрийн үнэлгээ, хөдөлмөрийн харилцааг дэмжих эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;
- 3.10. Цэргийн албан хаагчдыг үндэсний томоохон бүтээн байгуулалтанд оролцуулах замаар мэргэшсэн ажиллах хүчний нөөцийг бий болгох, залуучууд алба хаах хугацаандаа орлого, хуримтлалыг нэмэгдүүлэх “Нэг үндэстэн-Нэг цэрэг” хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлэх чиглэлийг Засгийн газарт өгч ажиллах;
- 3.11. Баялаг бүтээгчдэд учирч буй төрийн дарамт, хяналт шалгалт болон татвар, зээлийн хүндрэл, авилга хүнд суртлыг арилгахад чиглэсэн эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
- 3.12. Хоёр хөршийг холбосон эдийн засгийн бүс (коридор)-ийг хөгжүүлэх, ре-экспортыг өргөжүүлэх, эдийн засгийн чөлөөт бүсүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, гуравдагч хөрштэй хийх худалдааны хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжсэн эрх зүйн орчны шинэчлэлийг санаачлан ажиллах;
- 3.13. Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогоор баталсан дотоодын төмөр замын нэгдсэн сүлжээг байгуулж, хоёр хөршийн болон дэлхийн зах зээл рүү чиглэсэн төмөр замын чиглэлүүдийг барьж байгуулах бодлогыг дэмжиж ажиллах;
- 3.14. Сэргээгдэх эрчим хүчний нөөцийг ашиглах, эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар эрчим хүчний дотоодын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, гадаад зах зээлд нийлүүлэх бодлогыг дэмжих;
- 3.15. Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, метан хийг ашиглах, нүүрснээс хийн цэвэр түлш гарган авах зэрэг эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх талаарх санаачилга, хамтын ажиллагааг дэмжих;
- 3.16. Санхүүгийн болон хөрөнгө оруулалтын зах зээлийн үйл ажиллагааг эдийн засгийг тэлэх бодлогод уялдуулан зохион байгуулах эрх зүйн орчныг сайжруулах санаачилгыг дэмжих;

### **ДӨРӨВ.ЭКОЛОГИЙН ТЭНЦВЭРИЙГ ХАНГАЖ, ЭХ НУТГАА ХАМГААЛСАН ЕРӨНХИЙЛӨГЧ БАЙНА.**

*Монгол орныхоо байгалийн нөөц баялагийг зөв зохистой ашиглах, байгальд учруулж буй хүний болон аж үйлдвэрийн хор хөнөөл, хүлэмжийн хийн ялгарал, уур амьсгалын өөрчлөлтийг багасгах замаар экологийн тэнцвэрт байдлыг хадгалж, унаган байгалаа хойч үедээ өвлүүлэн үлдээхэд онцгой анхаарч ажиллана.*

*Бүс нутаг, дэлхий нийтэд хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрт нэгдэж, тэдгээрийн үр шимийг хүртэгч байхыг эрмэлзэнэ. Үүнд:*

- 4.1. Уламжлалт ёс заншлаа дээдэлсэн хандлага, зөв дадлыг төлөвшүүлэх, экологид ээлтэй үйлдвэрлэл, эко-техник, технологийг Монгол Улсад нутагшуулж, нэвтрүүлэх бодлогыг дэмжиж ажиллах;
- 4.2. Байгаль орчинд сөргөөр нөлөөлж буй уур амьсгалын өөрчлөлт, агаарын болон хөрсний бохирдол, усны нөөцийн хомсдол, хөрсний элэгдэл, цөлжилт, бэлчээрийн




- доройтолд онцгой анхаарч экологийн тэнцвэрт байдлыг хадгалан хамгаалахад Монгол төрийн бодлогыг хандуулж ажиллах;
- 4.3. Нийслэл болон хүн ам олноор төвлөрсөн хот суурингуудын агаар, хөрсний бохирдол, түүнээс үүдэн гарч буй хор уршгийг Үндэсний аюулгүй байдлын онцгой түвшинд авч үзэн үйл ажиллагааныхаа тэргүүлэх чиглэл болгон ажиллах;
  - 4.4. Үйлдвэрлэлийн болон ахуйн хог хаягдал, бохирыг дахин боловсруулах замаар хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчны бохирдлыг багасгах, хамгаалах, сэргээх бодлого, үйл ажиллагааг дэмжинэ. Хог хаягдлыг ангилах, дахин боловсруулах системийг бүрдүүлж, үнэлгээжүүлэх санаачилгыг дэмжиж ажиллах;
  - 4.5. Агаарын бохирдлыг бууруулах зорилтын хүрээнд бүх төрлийн байгальд ээлтэй эко-техник, технологи /гибрид, цахилгаан машин/ татвар хураамжийг нэмэгдүүлэхийг хориглох бодлого боловсруулж хэрэгжүүллийн төлөө ажиллах;
  - 4.6. Үндэсний зан заншил, уламжлал, түүх, соёл, унаган байгаль, нүүдэлчин ахуйд түшиглэсэн нийслэл, аймаг, бүс нутгийн онцлогт тохирсон болон олон улсын түвшинд урлаг, соёлын аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлэхийг дэмжин ажиллах;
  - 4.7. Түүхий нүүрс, занарыг дахин боловсруулж утаагүй хатуу түлш, шингэн түлш, эрчим хүч үйлдвэрлэх аливаа санаачилгыг дэмжих;
  - 4.8. Байгалийн унаган төрхөө хадгалсан газар, цэнгэг усны нөөц, томоохон гол мөрний урсац бүрэлдэх эхийг улсын тусгай хамгаалалтанд авах, хур тунадас, гадаргын ус хуримтлуулах улсын хэмжээний усан сан байгуулах, Улаанбаатар хот орчмын гүний усыг хэмнэх, гадаргын ус ашиглах, хаягдал бохир усыг цэвэрлэн дахин ашиглах технологи нэвтрүүлэхийг дэмжих;
  - 4.9. Нэн ховор, устаж үгүй болох аюул нүүрлэсэн, гоц ашигт ургамал, ан амьтны төрөл зүйлийг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэхэд чиглэсэн амьд байгалийн тэнцвэртэй байдлыг хангаж ажиллах;

### **ТАВ.ЭКСПОРТЫН ШИНЭ ЭРИНГ ЭХЛҮҮЛСЭН, ЭРХ ТЭГШ ГАДААД ХАРИЛЦААГ ХӨГЖҮҮЛЭГЧ ЕРӨНХИЙЛӨГЧ БАЙНА.**

*Монгол Улсын тусгаар тогтнол, бие даасан бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, хил хязгаарын халдашгүй дархан байдлыг сахин хамгаалж, Монголын ард түмний хийсэн ардчилсан сонголтыг улам баталгаажуулах, үндэснийхээ эрх ашгийг дээдэлсэн эрх тэгш хамтын ажиллагааг эрхэмлэх нь Ерөнхийлөгчийн гадаад бодлогын тэргүүлэх зарчим байна.*

*Эдийн засгийн хувьд бие даасан, хараат бус, эрчимтэй хөгжих таатай орчныг бүрдүүлж, бүс нутаг, олон улсын түвшинд харилцан ашигтай, үр өгөөжтэй хамтын ажиллагааг өргөжүүлэн, Монгол Улсад үйлдвэрлэсэн мэдлэг, үнэ цэнэ шингэсэн бүтээгдэхүүнийг экспортлох зах зээлийг тасралтгүй тэлэх нь Ерөнхийлөгчийн онцгой анхаарч ажиллах чиглэл байна.*

*Дэлхий даяар тархан суурьшсан Монгол туургатнууддаа хандан найрсаг, идэвхтэй бодлого явуулж, Монгол үндэстнийхээ түүх, өв соёл, бахархлыг олон улсад идэвхтэй сурталчлан түгээн дэлгэрүүлэх замаар гадаад харилцаанд зөөлөн хүчний дипломат бодлого явуулах тал дээр онцгой анхаарч ажиллана. Үүнд:*



- .1. Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдал, үндэсний язгуур эрх ашгийг эрхэмлэсэн, тууштай гадаад бодлого хэрэгжүүлэх нь Ерөнхийлөгчийн нэн тэргүүний зорилт байх;
- .2. Эдийн засгийн хамтын ажиллагааг эн тэргүүнд тавьсан гадаад харилцааг дэмжинэ. Үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүний экспортыг эрс нэмэгдүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг татаж, дэвшилтэт технологи нэвтрүүлэх замаар үндэсний үйлдвэрлэлээ дэмжихийг гадаад бодлогын тэргүүлэх чиглэл болгохыг дэмжих; Бараа бүтээгдэхүүнээ дэлхийд гаргах эрмэлзэлтэй баялаг бүтээгчдийг дэмжиж, экспортыг урамшуулах зорилго бүхий санаачилга, үйл ажиллагааг тууштай дэмжих;
- .3. ОХУ, БНХАУ-тай иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаагаа гүнзгийрүүлж, эдийн засгийн харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх бодлогыг дэмжиж ажиллах;
- .4. Монгол Улсыг олон улсын агаарын болон автозам, төмөр замын дамжин өнгөрөх тээврийн зангилаа болгох, бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдэн ороход үндэсний язгуур эрх ашгийг эрхэмлэн манлайлан оролцох;
- .5. Гадаад худалдаа, хөрөнгө оруулагчдын аж ахуйн үйл ажиллагааг хөнгөвчилсөн технологи, үйлдвэрлэлийн чөлөөт бүсийг хууль тогтоомжид нийцүүлэн байгуулахыг дэмжих;
- .6. Бусад улс орнуудтай хийсэн татвар давхардуулан ногдуулахгүй байх тухай гэрээ, мөн эдийн засгийн ач холбогдол бүхий бусад хэлэлцээрийг эрх тэгш, харилцан ашигтай хамтран ажиллах зарчмын дагуу Монгол Улсын язгуур эрх ашигт нийцүүлэх чиглэлээр санаачилгатай ажиллах;
- .7. Гуравдагч хөршийн бодлогын хүрээнд өндөр хөгжилтэй, ардчиллын үнэт зүйлсийг дээдэлдэг улс орнуудтай улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талт харилцаа, хамтын ажиллагааг идэвхтэй хөгжүүлэхийг дэмжих;
- .8. Монгол улстай эртний түүхэн харилцаатай Энэтхэг болон Төв Азийн орнууд, Турк зэрэг орнуудтай үүсгэж буй хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлж, соёл, хүмүүнлэгийн харилцаагаа гүнзгийрүүлж, аялал жуулчлал болон бизнес, эдийн засгийн бусад салбарын хамтын ажиллагааг дэмжих;
- .9. Гадаад бодлогыг улс төржилтөөс ангид, нэгдмэл байлгах зарчмыг тууштай баримталж, төр засгийн байгууллагуудын гадаад харилцааг нэгдсэн зохицуулалттай болгох бодлого баримтлах;
- .10. Гадаадад амьдарч байгаа Монгол Улсын олон мянган иргэдийн эрх ашгийг хамгаалах, ажиллаж амьдрах нөхцөлийг сайжруулах, эх орондоо чөлөөтэй зорчих, Монгол Улсынхаа улс төр, эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулах боломж бололцоог нь хангахад байнга анхаарах;
- .11. Гадаадад богино хугацаагаар зорчиж байгаа иргэдэд тухайн орондоо зорчих визний нөхцөлийг хөнгөвчлөх, зорчиж байгаа үедээ үндсэн эрхээ эдлэх, эрх нь зөрчигдсэн үед бүх талын тусламж дэмжлэг авдаг байх нөхцөлийг бүрдүүлэхийн төлөө онцгойлон анхаарч, эрх зүйн орчин бүрдүүлэх;
- .12. НҮБ болон олон улсын бусад байгууллагын хүрээнд Монгол Улсын баримталж буй уламжлалт идэвхтэй байр суурийг цаашид ч хадгална. НҮБ-ын шийдвэрийн үндсэн дээр, түүний ивээл дор хэрэгжүүлж буй энхийг сахиулах ажиллагаанд олон улсын хамтын нийгэмлэгийн хариуцлагатай гишүүний хувиар цаашид ч идэвхтэй оролцох;



- .13. Монгол Улсын оршин байгаа бүс нутаг болох Зүүн Хойд Азийн энх тайван, тогтвортой байдлыг ханган бэхжүүлэхийн төлөөх Монгол Улсын байр суурийг бататган бүс нутгийн орнуудын эдийн засгийн хамтын ажиллагаа, интеграцчиллыг хөгжүүлэх чиглэлээр тодорхой, бодитой санал санаачилгыг гаргаж ажиллах;
- .14. Монгол Улсын Үндсэн Хууль, Гадаад бодлогын болон Батлан хамгаалах бодлогын үзэл баримтлалын хүрээнд гуравдагч хөршийн бодлогыг улам эрчимжүүлж, тэдний бодит сонирхлыг Монголд бий болгох, тэдний зүгээс Монголд оруулж буй хөрөнгө оруулалтад эрх тэгш, шударга, ил тод нөхцөл олгож, эрх ашгийг нь хуулийн дагуу хамгаалах;
- .15. Дэлхий дахины болон бүс нутгийн тогтвортой байдлыг хангах эрмэлзэл бүхий олон талт олон улсын байгууллагуудтай тогтвортой хамтын ажиллагааг үргэлжлүүлэх;
- .16. Цөмийн зэвсэггүй бүс байх, зэвсэглэлд үл нэгдэх болон терроризмын эсрэг хамтын ажиллагааг үргэлжлүүлэх, экологийн тэнцвэртэй байдлыг хангах, мэдээллийн аюулгүй байдал, хүний эрх, боловсролын солилцооны хөтөлбөрийг дэмжих;
- .17. Монгол улсын нэр хүндийг өргөж, дэлхийд түгээн сурталчилж буй иргэд, аж ахуй нэгжийн үйл ажиллагааг анхааран дэмжих;
- .18. Монгол Улсын түүх соёл, уламжлалыг дэлхийн хэмжээнд түгээн дэлгэрүүлэхэд анхаарал тавьж, уламжлалт болон тоон технологиор бүтээсэн уран бүтээл, агуулга контентийг (дүрст бүтээл, дуу хөгжим, бусад оюуны бүтээлүүд) олон улсын зах зээлд экспортлох санаачилга, төсөл, хөтөлбөрийг дэмжиж ажиллах;
- .19. Олон улсын хэмжээнд Монгол судлалыг түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлж, шаардлагатай эх сурвалжийг эх орондоо буцаан авчрах талаар санал, санаачилгатай ажиллах;
- .20. Монгол туургатан дэлхийн иргэдтэй үүсгэж буй хүмүүнлэгийн харилцааг идэвхжүүлж, түүх судлал, соёл, урлаг, спорт, аялал жуулчлалын салбарт өргөн хүрээтэй хамтын ажиллагааг хөгжүүлэхэд анхаарах;

